

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

---

№ 18/2

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2018 оны 6 дугаар сарын 11, 15-ны өдрүүдэд хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав. Хуралдаанаар бодлогын хүү болон хэрэглээний зээлийн хувьд өр-орлогын дээд харьцааг тогтоох тухай арга хэмжээнүүдийн талаар хэлэлцлээ.

МБХ-ны эхний хуралдаанаар эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, инфляци, эдийн засгийн өсөлт, гадаад эдийн засгийн орчин, төсөв, хөрөнгө санхүүгийн зах зээл, эдгээрт гарч буй өөрчлөлтүүдийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци мөнгөний бодлогын үндсэн зорилттой нийцтэй байгаа бөгөөд цаашид зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байгааг МБГ-аас онцлов. Зарим татварын өөрчлөлт, ХҮИ-ийн сагс, жин болон аргачлалын өөрчлөлт зэрэг нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө аажмаар багасч, мөн импортын нөлөө буурч байгаагаас байгаагаас шалтгаалж жилийн инфляци буурч байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэж, шатахууны үнэ өсөхөөр хүлээгдэж байгаа хэдий ч нэг удаагийн шинжтэй инфляцийн нөлөө үргэлжлэн буурах, импортын барааны үнэ харьцангуй тогтвортой байх зэргээс үүдэн жилийн инфляци 2018 онд зорилтот түвшний орчимд тогтворжих хүлээлттэй байна.

Эдийн засгийн идэвхжил цаашид нэмэгдэхээр байна. Энд экспортын голлох эрдэс бүтээгдэхүүний үнэ 2018 онд өндөр түвшинд хадгалагдах, Оюу толгойн алтны агууламж нэмэгдэх нь уул уурхайн салбарын өсөлтийг нэмэгдүүлэхээр байна. Уул уурхайн бус салбарын хувьд хөрөнгийн дотогшлох урсгал сайжрах, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэх зэрэг хүчин зүйлсийн голлох нөлөөгөөр идэвхжил үргэлжлэн сайжрахаар байна.

Гадаад эдийн засгийн төлөв хүлээлтээс сайжирсныг танилцуулав. Үүнд Хятадын эдийн засгийн өсөлт 2018 оны I улиралд хүлээлтээс өндөр буюу 6.8 хувь, Евро бүсийн эдийн засаг 2.5 хувьд хүрсэн нь голчлон нөлөөлжээ. Мөн 2017 оны сүүлээс эхлэн Монгол улсын экспортын гол нэрийн барааны дэлхийн зах зээл дээрх үнэ өсч байна. Тодруулбал, алт, нүүрс, газрын тосны үнэ өмнөх төсөөллөөс өссөн. Харин 2019 оноос төмрийн хүдэр, хүрэн нүүрсний үнэ буураад худалдааны нөхцөлийн индекс буурахад нөлөөлөхөөр байна.

Урсгал дансны алдагдал тэлсэн ч санхүүгийн дансны цэвэр орох урсгал илүү ихээр нэмэгдсэнээр нийт төлбөрийн тэнцэлийн ашиг нэмэгдэхээр байгааг дурдсан. Урсгал дансны хувьд түүхий эдийн үнийн төсөөлөл сайжирч, экспортын орлого нэмэгдэхээр байна. Гэхдээ уул уурхайн салбарын идэвхжил, хэрэглээний зээлийн өсөлтөөс шалтгаалан импорт хурдтай тэлж байгааг тайлбарлав. Санхүүгийн тэнцлийн хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), гадаад зээл нэмэгдэхээс шалтгаалан тус дансны ашиг өсөхөөр байна. Гадаад валютын нөөц үргэлжлэн нэмэгдэж, импортын 8-9 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрээд байна.

МБЗ-ийн гишүүдэд Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, төсвийн алдагдлын ойрын төлөвийг танилцууллаа. Төсвийн орлогын гүйцэтгэл сайжран төсвийн алдагдал буурч, алдагдлыг дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлага багасч байна. Энэ нь банкны систем дэх зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх нөлөөтэйг дурдсан.

Мөнгөний нийлүүлэлт, зээлийн өсөлт нэмэгдэж байна. Банкуудаас иргэдэд олгож буй хэрэглээний зориулалттай зээл хурдацтай нэмэгдэж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голчлон тодорхойлсон хэвээр байна. Харин эдийн засгийн идэвхжлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зориулалттай бизнесийн зээл 2018 оны эхнээс алгуур нэмэгдэх хандлага ажиглагдаж эхэлсэн.

Мөн төсөөлөл боловсруулахад учирч буй дараах тодорхой бус байдлыг хэлэлцэв. Дотоод орчны хувьд нийлүүлэлт талаас цаг агаар, зуншлагын нөхцөл байдал, шатахууны үнийн талаарх Засгийн газрын зохицуулалт, эрэлт талаас цалин нэмэгдэх, төсөөлснөөс импорт илүү эрчимжих, томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэх зэрэг тодорхой бус байдлуудыг онцолсон бол гадаад эдийн засгийн хувьд геополитикийн асуудлууд болон Трампын худалдааны бодлогын эрдэс бүтээгдэхүүний үнэд үзүүлэх нөлөө, Хятадын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй дотоод болон гадаад бодлогын өөрчлөлт зэрэг нь тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгааг хэлэлцлээ.

Суурь төсөөллөөр 2018 онд инфляцийн түвшин зорилтот түвшнээс доогуур буюу 7.1 хувь, эдийн засгийн өсөлт 5.7 хувь байхаар байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэх хэдий ч цаашид инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байгааг онцлов.

Бодлогын хүүний тухайд мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах санал гаргасан. Мөнгөний бодлогын хорооны хуралдаанаар гишүүд мөнгөний бодлогын газрын саналыг шүүмжлэх, дэмжих хэлбэрээр хэлэлцүүлэг өрнөв.

Мөнгөний бодлогын хорооны дийлэнх гишүүдийн хувьд бодлогын хүүг 4 удаа шат дараатайгаар бууруулсан нөлөө хараахан гарж амжаагүй байгаа гэж үзэн бодлогын хүүг энэ удаа хэвээр хадгалах саналыг дэмжив. Мөн 2019-2020 онд сонгуультай холбоотойгоор эдийн засагт тодорхой бус байдлууд нэмэгдэх эрсдэлтэй байгааг дурдсан. Инфляци хэдийгээр буурах төсөөлөлтэй байгаа ч цаашид өсөх эрсдэлүүд байна. Үүнд сургалтын төлбөр, эрчим хүчний үнэ, шатахууны үнэ зэргийг дурдлаа.

Гишүүд бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах зорилготой нийцтэй байгааг онцоллоо. Мөн бодлогын хүүний эдийн засагт үзүүлэх нөлөөлөл 2 жилийн дараа бүрэн гардаг бөгөөд 2019 оноос зээлийн идэвхжил нэмэгдэнэ.

Ийнхүү мөнгөний бодлогын хорооны гишүүд өмнөх бодлогын хүүг бууруулсан нөлөө эдийн засагт бүрэн гарч амжаагүй байгаа, мөн Тавантолгойн төсөл хэрэгжиж эхлэх тохиолдолд эдийн засагт халалт үүсч, инфляци нэмэгдэж улмаар бодлогын хүүг эргэн өсгөхөд хүргэх эрсдэлтэй байгаа гэж үзэн одоогийн хүүгийн түвшинд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах зорилгоор бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах саналыг 100% дэмжлээ.

Хурлын дараагийн хэсэгт макро зохистой бодлогын хүрээнд иргэдийн хэрэглээний зээлд өр, орлогын харьцааны дээд хязгаар тогтоох үндэслэлийн талаар хэлэлцлээ.

Банкны системийн хэмжээнд 2018 оны I улирлын байдлаар нийт зээл 11.4 хувиар, үүнээс хэрэглээний зээл 47.3 хувиар өссөн. Хэрэглээний зээлийг дагаад өрхийн нийт өр өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсч 9580.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн 57.6 хувийг бүрдүүлж байгааг танилцуулсан. Ажлын байр нэмэгдэж, өрхийн орлого дорвитой өсөөгүй үед ирээдүйн орлогыг барьцаалан өрхийн өр, зээлийг хурдацтай нэмэгдүүлэх нь түр хугацаанд хэрэглээгээр дамжин эдийн засгийн өсөлтийг дэмжих ч дунд хугацаанд эдийн засгийн өсөлт саарах, иргэдийн орлого хүлээлтэнд хүрч өсөхгүй, ажлын байр нэмэгдэхгүй тохиолдолд хэрэглээний зээлийн чанар муудаж санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулна. Түүнчлэн ирээдүйн орлогоо урьдчилан авч хэрэглэсэн иргэд тодорхой хугацааны дараа хэрэглээгээ хумиж эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг тухай олон улсын судалгааны үр дүнг тайлбарлав.

Зээлийн төлбөрийг иргэдийн татварын дараах орлогын 50-100 хүртэл хувьтай тэнцэхүйц хэмжээгээр олгож байна. Цалин, тэтгэвэр зэрэг иргэдийн тогтмол орлогыг барьцаалсан хэрэглээний зээлийн хувьд зээлийн сарын төлбөр нь иргэдийн нэрлэсэн орлогын тодорхой хувиас давахгүй байхаар банкууд өөрийн дотоод журамдаа тусгадаг хэдий ч үүнийг тогтмол нэмэгдүүлэх чиглэлд өөрчилж байна. Мөн банкууд шинэ харилцагч татах, хуучин харилцагчаа хадгалахын тулд энэ харьцааг өргөн ашигладаг байна.

Түүхий эдийн үнэ эргэн буурах эсвэл манай гадаад эрэлт багасах тохиолдолд өрхийн орлого буурч, өрхийн хэрэглээ хумигдах, эдийн засгийн өсөлт огцом буурах, санхүүгийн тогтворгүй байдал үүсгэх, хямралыг гүнзгийрүүлэх эрсдэлтэй болохыг хэлэлцлээ.

Иймд банкны системийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бага орлоготой иргэдийг өрийн циклээс гаргах, тэдний амжиргааг хамгаалах, банкны эх үүсвэрийг бизнес, хөрөнгө оруулалт, ажил олголтыг дэмжих салбарт чиглүүлж, иргэдийн орлогод түшиглэсэн өнөөгийн ба ирээдүйн тогтвортой хэрэглээг дэмжих зорилгоор өр, орлогын харьцаа өндөр, зээлээ олон давтамжтай сунгадаг иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг аажмаар сааруулах шаардлагатай гэж үзсэн.

Цалин, тэтгэвэр, хэрэглээний бусад зээлийн хувьд өр, орлогын харьцааг татварын дараах цэвэр орлогын 65 хувиар, зээлийн хугацааг 36 сараас ихгүй байхаар тогтоож шинээр олгох зээлийн хувьд 2019 оны 1 сарын 1-нээс мөрдөх, өмнө олгосон зээлийн нөхцөлийг өөрчлөх тохиолдолд мөн дээрх харьцаа үзүүлэлт, хугацааны хязгаарлалтыг баримтлах саналыг хэлэлцэв. Мөн Хөдөлмөр, нийгийн хамгааллын яамнаас тэтгэвэрийн зээлийн хувьд өр, орлогын харьцаа 70 хувь байх нь зохимжтой гэсэн санал гаргасныг хэлэлцэв.

Мөнгөний бодлогын хорооны нэг гишүүн хэрэглээний зээлийн өсөлтийг системийн шинжтэй аюул гэж одоохондоо үзэхгүй байгаагаа илэрхийлсэн. Энэхүү шийдвэр нь төв банк зарим арилжааны банкны харьцангуй давуу талаа ашиглахад нь саад болж байгаа мэт харагдах эрсдэлтэй. Иймд дүрэм журам гаргахгүйгээр банкинд цалин тэтгэвэрийн зээлийг хязгаарлах талаар санал зөвлөмж өгөөд ирэх он хүртэл шийдвэрээ харзناх нь зүйтэй. Ирэх

онд хэрэглээний зээлийн өсөлт үргэлжлэн том асуудал хэвээр байвал тухайн үед нь уг шийдвэрийг гаргах хэрэгтэй гэсэн саналыг илэрхийлсэн болно.

Зарим гишүүд иргэдийн хувьд санхүүгийн мэдлэг боловсрол дутмаг, орлогоо 100 хувь барьцаалаад зээл авах тохиолдлууд гарч байгааг онцолсон. Бизнесийн зээл дорвитой өсөхгүй байгаа нь цаашид ажлын байр, иргэдийн орлого хурдацтай нэмэгдэх боломжийг хязгаарлаж байна. Үүнтэй зэрэгцээд хэрэглээний зээл хурдацтай өсч, иргэд орлогынхоо дийлэнх хувийг барьцаалж хэрэглээндээ зарцуулж байгаа нь өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх, цаашлаад санхүүгийн салбарын тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул хэрэглээний зээлийг хязгаарлах, банкны эх үүсвэрийг бизнесийн салбарт чиглүүлэх, иргэдийн амжиргааг хамгаалах, санхүүгийн салбарт үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй гэсэн саналыг илэрхийлэв. Ингэхдээ энэхүү арга хэмжээг иргэдийн өнөөгийн хэрэглээ, өрхийн санхүүд гэнэтийн дарамт учруулахгүйгээр, аажмаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт хийв.

Мөнгөний бодлогын хорооны гишүүд өр, орлогын харьцааны хязгаар тогтоох бодлогын арга хэмжээ нь цаг хугацааны хувьд одоо гаргах шаардлагатай шийдвэр гэдэгтэй санал нэгдэж, өр, орлогын харьцааны одоогийн дундаж түвшин буюу 69 хувьтай ойролцоо, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналтай нийцтэйгээр уг харьцааг 70 хувиар тогтоох нь зүйтэй гэж тогтов. Энэхүү арга хэмжээ нь хурдацтай өсч буй хэрэглээний шинжтэй зээлийг даамжруулахгүй, санхүүгийн нөөцийг ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлж, иргэдийг өрийн дарамтад гүнзгий оруулахгүй байхад нөлөөтэй болно.

Ийнхүү МБХ-ны гишүүд иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох саналыг 100% дэмжлээ.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны МБХ-ны 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах, иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоох шийдвэр гаргалаа. Бодлогын хүүний шийдвэрийг 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн, өр, орлогын харьцааны шийдвэрийг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтов.